# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (339)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Улсын Их Хурлын гишүүн Л. Гүндалайн бүрэн эрхийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Орон сууц хувьчлах тухай*

- *Улсын эталон батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2004 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны хоёрдугаар сарын 12 № 6 (339)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 61. | Улсын Их Хурлын гишүүн Л. Гүндалайн бүрэн эрхийн тухай | Дугаар 8 | 73 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 62. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 187 | 74 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 63. | Орон сууц хувьчлах тухай | Дугаар 246 | 80 |
| 64. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 249 | 80 |
| 65. | Нэрэмжит болгох тухай | Дугаар 250 | 81 |
| 66. | Ерөнхий консулыг томилох тухай | Дугаар 251 | 81 |
| 67. | Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай | Дугаар 253 | 81 |
| 68. | Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | Дугаар 256 | 81 |
| 69. | Улсын эталон батлах тухай | Дугаар 257 | 86 |
| 70. | Үндэсний хороо, журмын тухай | Дугаар 258 | 86 |
| 71. | Дүрэмд нэмэлт оруулах тухай | Дугаар 259 | 89 |
| 72. | Монголд зочлох жилийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай | Дугаар 260 | 89 |
| 73. | 2004 оныг усны бодлогын шинэтгэлийн жил болгох тухай | Дугаар 261 | 89 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

**Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалайн бүрэн эрхийн тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалайд холбогдох эрүүгийн хэргийг түүний Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэхгүйгээр шийдвэрлэх боломжтой байх тул Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалайн бүрэн эрхийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Улаанбаатар хот

Дугаар 187

### Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, нийтийн аж ахуй, үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэл, батлан хамгаалах, боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Рэгдэлийн Рэгзэндорж -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны өндөр настан, ахмад багш
2. Дуламсүрэнгийн Самданжамц -Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн "Шилмэл адуу" төслийн удирдагч
3. Мөнхийн Эрдэнэ -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Улаанбаатар гурил" ХХК-ийн гүйцэтгэх захирал
4. Лувсангийн Эрдэнэчулуун -Гадаад хэргийн сайд

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

1. Данаагийн Баатар -Зэвсэгт хүчний жанжин штабын захиргаа, удирдлагын хэлтсийн орлогч дарга, хурандаа
2. Цэрэндоржийн Доржхүү -Зэвсэгт хүчний цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны орлогч дарга, хурандаа

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Сейлханы Аким -Баян-Өлгийн аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн магадлан шинжлэгч их эмч
2. Рэгдэнгийн Александр -Өмнөговь аймгийн Гурвантэс сумын мал эмнэлэг, үржлийн "Баясах хайрхан" ББН-ийн малын их эмч
3. Готовын Алтан -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Алтжин" ХХК-ийн гүйцэтгэх захирал
4. Жамбаагийн Амаржаргал -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн чанарын хяналтын хэлтсийн орлогч дарга
5. Янжингийн Амарсайхан -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дизайнерч
6. Дамбадаржаагийн Амгалан -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
7. Пүүвэнгийн Ариунболд -Улсын циркийн акробатын багш
8. Тогоогийн Баатар -Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн албаны дарга
9. Цэрэн-Очирын Бадамцоо -Завхан аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч
10. Лувсаншаравын Балданмагсар -Говьсүмбэр аймгийн "Говьгео" ХК-ийн орлогч захирал
11. Бумбаагийн Банди -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын автобаазын дарга
12. Чагнаадоржийн Банзар -Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн, их эмч
13. Самбуудашийн Банзрагч -Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга
14. Цэсэдийн Банзрагч -Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын хэлтсийн дарга
15. Чулуунбатын Батгэрэл -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын балетын гоцлол бүжигчин
16. Магваны Батжаргал -Өвөрхангай аймгийн Хужирт сум дахь сум дундын эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч
17. Бадамын Бат-Очир -Төв аймгийн Зуунмод сумын өндөр настан, малын ахмад эмч
18. Жамъянсүрэнгийн Батсуурь -Дорноговь аймгийн Засаг дарга
19. Гончигийн Баттогтох -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн холбооны цехийн дарга
20. Дэжмаагийн Баярсайхан -Завхан аймгийн Хөдөлмөр зохицуулалтын албаны дарга
21. Батхүүгийн Баярхүү -Нийслэлийн барилга угсралт, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн Зүүнхараа дахь "Спирт бал бурам" ХК-ийн дэд захирал
22. Намсрайн Бумцэнд -Нийслэлийн Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын хэлтсийн дарга
23. Дашцэрэнгийн Буяндалай -Малын удмын сангийн үндэсний төвийн захирал
24. Шархүүгийн Галсандулам -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн газрын орлогч дарга
25. Бат-Очирын Ганбаатар -Нийслэлийн "Дулааны 3 дугаар цахилгаан станц" ХК-ийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер
26. Зоригтын Ганбаатар -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах

"Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захиралын орлогч

27. Далхжавын Ганбат -Нийслэлийн "Гэрэлтүүлэг чимэглэл" компанийн вакуумчин

28. Цэрэнсэрээтэрийн Ганболд -Нийслэлийн барилга, угсралт, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн гүйцэтгэх захирал

29. Чимиддоржийн Ганзориг -Үйлдвэр, худалдааны сайд

30. Даваажавын Ганхуяг -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Бридж" группийн ерөнхийлөгч

31. Тогоочийн Гомбосүрэн -Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, тэслийн удирдагч

32. Базарын Гонжид -Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын үржлийн албаны ерөнхий мал зүйч

33. Дамбийн Гоошоохүү -Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн Ундраа" цогцолбор сургуулийн биеийн тамирын багш

34. Тунсагийн Гэндэнжамц -Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн "Зэлтэр" ХХК-ийн ерөнхий мал зүйч

35. Шагдарсүрэнгийн Даваажав -Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын мал эмнэлэг, үржлийн албаны дарга

36. Дашцэрэнгийн Даваасүрэн -Нийслэлийн цэцэг ургамлын таримал үржүүлэг, борлуулалтын "Кактус" ХХК-ийн ерөнхий захирал

37. Сэр-Одын Давагсамбуу -Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ахмадын хорооны дарга

38. Будын Дамдинсүрэн -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин

39. Жигжидийн Дамдинсүрэн -Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн технологич их эмч

40. Гүржавын Дамчаабадгар -Өвөрхангай аймгийн Хужирт сумын малчин, төр, захиргааны ахмад ажилтан

41. Дамбадоржийн Дашболд -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий хэмжилзүйч

42. Загдын Дашжаргал -Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжээч их эмч

43. Даваагийн Долгорсүрэн -Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Улаанбаатар палас"-ын ерөнхий тогооч

44. Бахаавайн Дүгэрээ -Нийслэлийн Мал эмнэлэг, үржлийн газрын ерөнхий эмч

45. Базарын Жадамбаа -Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

46. Равдандоржийн Жанчивдорж -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын хэсгийн дарга

47. Оюунбилэгийн Жигмэддорж -Хэнтий аймгийн Батноров сумын "Булган сурэг" хувийн мал эмнэлгийн малын эмч

48. Далхжавын Зоригт -Нийслэлийн "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн албаны дарга

49. Чойжамцын Ичинхорлоо -Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжээч их эмч

50. Лхаажавын Ишханд -Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 101 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

51. Дондовын Лхагва -Нийслэлийн "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн борлуулалтын албаны мастер

52. Туталхүүгийн Лхагважав -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий эрчим зүйн хэлтсийн ахлах инженер

53. Даваагийн Лхагвадорж -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын ерөнхий инженерийн орлогч

54. Бэрэнбаралын Лхагвасүрэн -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Атар-Өргөө" ХК-ийн ерөнхий захирал

55. Моононгийн Мөнхбуянт -МОНЦАМЭ агентлагийн Тамгын хэлтсийн дарга

56. Бадарчингийн Мяхдадаг -Улсын мал эмнэлэг, үржлийн газрын орлогч дарга бөгөөд малын үржлийн албаны дарга

57. Санжаагийн Нуваан -Төв аймгийн Борнуур сумын "Даваанбулаг" ХХК-ийн мал зүйч

58. Мижидийн Олонбаяр -Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

59. Лхүндэвийн Оргодол -Өвөрхангай аймгийн Сант сумын Засаг даргын Тамгын газрын малжуулах тэслийн ажилтан, малын их эмч

60. Гэндэнжавын Отгонпүрэв -Нийслэлийн "Багануур" ХК-ийн экскаваторын машинч

61. Тойвгоогийн Очирхуяг -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хүдрийн ил уурхайн экскаваторын машинч

62. Ширчингийн Өлзийбаатар -Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын үржлийн албаны дарга

63. Чухамсайханы Пурэв -Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын үржлийн албаны дарга

64. Төмөрийн Ренчинжүгдэр -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн технологийн автоматжуулалт, тооцоолон бодох техникийн цехийн дарга

65. Пүрэвсүрэнгийн Рина -Булган аймгийн Булган сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

66. Батдамбын Самбуу -"Монгол шуудан" ХХК-ийн санхүү бүртгэлийн хэлтсийн дарга

67. Аюушийн Сангаррагчаа -Говь-Алтай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн албаны дарга

68. Шоомбойн Үдэнбор -Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын арга зүйч эмч

69. Энэбишийн Үзмээ -Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Гүн-Энх" ХХК-ийн ерөнхий захирал

70. Лувсангийн Халтар -УБТЗ-ын олон улсын тээвэр зуучлалын төвийн захирал

71. Дамдины Хаянхярваа -Дархан-Уул аймгийн Засаг дарга

72. Жамбын Хүүхэнбаатар -Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

73. Ендонгийн Цог -Нийслэлийн чөлөөт уран бүтээлийн "Хас" ТВ студийн зөвлөх найруулагч, жүжигчин

74. Балдоржийн Цэвэгмид -Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор сургуулийн математикийн багш

75. Хайнзангийн Цэдэн-Иш -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өндөр настан, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан

76. Дашдондогийн Цэндбаатар -Нийслэлийн Баянзүрх дүүргийн мал эмнэлгийн "Баяндэмбэрэл" ХХК-ийн ерөнхий захирал

77. Долгорын Цэнджав -Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн сэтгүүл зүйн багш

78. Сэрээтэрийн Цэндсүрэн -ХААИС-ийн мал аж ахуйн бүтээгдэхүүн судлалын тэнхмийн багш

79. Сандуйн Цэрэндэжид -Нийслэлийн Яаралтай тусламжийн төвийн ерөнхий нягтлан бодогч

80. Сандуйн Цэрэн-Очир -Нийслэлийн Халаалтын зуухны ашиглалтын газрын механикч

81. Дэндэвийн Цэрэнчимэд -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр дунд сургуулийн нягтлан бодогч

82. Ангиагийн Цэцэгмаа -Нийслэлийн Баянгол дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч

83. Гомбын Цэцэгмаа -Нийслэлийн Баянгол дүүргийн 98 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

84. Магдаагийн Чулуунбаатар -Ховд аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан түшмэл

85. Бандийн Чутнай -Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

86. Заландарын Шаравсамбуу -Нийслэлийн "Тэрэлтүүлэг чимэглэл" компанийн ерөнхий инженер

87. Намхайдоржийн Энэбиш -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын инженер

88. Бат-Очирын Эрдэнэчимэг -Нийслэлийн үйлдвэрлэл, худалдаа, зуучлалын "Хөнгөн бетон" ХК-ийн гүйцэтгэх захирал

89. Гунгаагийн Юра -Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн шинжээч их эмч

90. Цэрэнбадамын Ядамсүрэн -Нийслэлийн нягтлан бодох бүртгэлийн "Мандах" дээд сургуулийн багш

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Дэлэгнямын Баатар -Батлан хамгаалахын их сургуулийн соёлын төвийн дарга, дэд хурандаа

2. Чүлтэмийн Баярсайхан -Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагч, хурандаа

3. Базарын Цоодол -Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн орон сууц ашиглалтын дарга, дэд хурандаа

4. Төрбатын Энхболд -Гал түймэртэй тэмцэх газрын гал унтраах 11 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэрэндашийн Аварзэд -Өмнөговь аймгийн Ноён сумын Ганзгад багийн малын бага эмч

2. Хайдарын Алейхан -Баян-Өлгийн аймгийн Дэлүүн сумын "Күнгэн" хувийн мал эмнэлгийн эзэн

3. Базарганьдын Алтанхуяг -Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Авзага трейд" ХХК-ийн талбайн даамал

4. Булгаагийн Алтанхуяг -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн материал техникийн хангамжийн баазын орлогч дарга

5. Баянсангийн Алтанцэцэг -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын хөгжимчин

6. Самбуугийн Ананд -Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нийслэлийн халдвар судлалын тасгийн дарга, их эмч

7. Мөнхийн Баасан -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн дулааны станцын хэсгийн дарга

8. Цогоогийн Баасандорж -Нийслэлийн барилга, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн газрын дарга

9. Чойжингийн Баасанжав -Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлгийн албаны дарга

10. Гомбожавын Баатар -Нийслэлийн алт хайгуул олборлолтын "Монгол алт" ХХК-ийн операторч

11. Дагвадоржийн Баатар -Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Зүлэгт нуга" ХХК-ийн малын их эмч

12. Санжийн Баатар -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн бичиг хэргийн хэлтсийн орчуулагч

13. Лайганы Байгалмаа -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн хийн үлээгүүрийн машинч

14. Цахиагийн Балдорж -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн засвар механикийн заводын хэсгийн дарга

15. Бат-Өлзийн Балтаа -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин

16. Ёлхорсүрэнгийн Батбаяр -Хөгжим бүжгийн коллежийн морин хуур хөгжмийн багш

17. Аюурзаны Батдэлгэр -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын бүжигчин

18. Даваагийн Батсүрэн -"Эрэл" ХХК-ийн Дархан-Уул аймаг дахь цементийн үйлдвэрийн ерөнхий инженер

19. Гүрбазарын Баттөр -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 48 дугаар дунд сургуулийн захирал

20. Ламжавын Бат-Эрдэнэ -Хөвсгөл аймгийн Тариалан сумын газар тариалангийн "Алтан дуулга" ХК-ийн трактор-комбайнч

21. Ядамын Баяраа -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн тоног төхөөрөмжийн засварчин

22. Цэгмидийн Болд -Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хот тохижилтын хэлтсийн дарга

23. Дашдаваагийн Болормаа -Нийслэлийн барилга, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн дистрибютерийн газрын захирал

24. Гочоогийн Борбаатар -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн суурь машинч

25. Гомбодоржийн Буянжаргал -Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга

26. Сүхийн Бямба -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын Белазын жолооч

27. Балдангийн Ганболд -Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн шинжээч бага эмч

28. Загдхүүгийн Ганболд -Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвийн хэмжилзүйн газрын дарга

29. Гэнэнгийн Гансүх -Нийслэлийн орон сууц, халаалтын аж ахуйн "Баруун Сэлбэ-Өргөө" салбарын сантехникийн засварчин

30. Сосорбурамын Гансүх -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эрчим хүчний цехийн цахилгаанчин

31. Галбадрахын Гантөмөр -Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн чанарын баталгаажуулалтын газрын дарга

32. Жүгдэрийн Даваа -Хөвсгөл аймгийн Арбулаг сумын "Мандал буяндэлгэрэх" хувийн мал эмнэлгийн эзэн

33. Гомбын Даваадорж -Төв аймгийн Сэргэлэн сумын мал эмнэлгийн "Гурван хангай" ХХК-ийн захирал

34. Баасанцэрэнгийн Даваасүрэн -Нийслэлийн шуудан холбооны 51 дүгээр салбарын ялгагч

35. Ламзавын Даваасүрэн -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн бутлуурчин

36. Эрдэнэ-Очирын Доржболд -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн тоног төхөөрөмжийн засварчин

37. Пүрэвийн Доржсүх -Дундговь аймгийн Адаацаг сумын "Бага Адаацаг" хувийн мал эмнэлгийн малын бага эмч

38. Батсүхийн Дэмбэрэл -Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн эксперт

39. Гомбосүрэнгийн Дэлшин -Улсын мал эмнэлэг, үржлийн газрын малын үржлийн албаны мэргэжилтэн

40. Самбуугийн Жамбалдорж -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн гагнуурчин

41. Лувсандашийн Жаргалсайхан -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн орон сууцны цехийн засварчин

42. Сосорбарамын Зоригтбаатар -Нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн "Баруун Сэлбэ-Өргөө" салбарын сантехникийн засварчин

43. Бадрахын Ичинхорлоо -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компанийн байцаагч

44. Жадамбын Лхагва -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн "Эрдэнэт" үйлдвэрийн техникийн цехийн хэсгийн дарга

45. Гомбосүрэнгийн Лувсан -Нийслэлийн барилга, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн хэлтсийн дарга

46. Сугарын Луймэд -Нийслэлийн шуудан холбооны 28 дугаар салбарын эрхлэгч

47. Базарсадын Мөнхбаяр -"Эрэл" ХХК-ийн Дархан-Уул аймаг дахь цементийн үйлдвэрийн ерөнхий технологич

48. Жадамбын Мөнхдалай -Ховсгол аймгийн Тосонцэнгэл сумын "Энх-Элит сүрэг" ХХК-ийн малын эмч

49. Шершнеегийн Мөнхөө -"Эрэл" ХХК-ийн Дархан-Уул аймаг дахь цементийн үйлдвэрийн ашиглалтын мастер

50. Даваагийн Мөнхцэцэг -Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын дунд сургуулийн бага ангийн багш

51. Балдангийн Мядагсүрэн -Булган аймгийн Булган сумын "Ачуут" мал эмнэлгийн шинжлэгч эмч

52. Батсүхийн Надмид -Нийслэлийн алт хайгуул олборлолтын "Монгол алт" ХХК-ийн бульдозерчин

53. Шаравын Намжаа -Улсын клиникийн төв эмнэлгийн эрчимт эмчилгээний тасгийн сувилагч

54. Хожгорын Намсрай -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйдвэрийн технологийн сургуулийн эрчим зүйч

55. Цэрэндашийн Наранхүү -Ховд аймгийн Чандмань сумын "Зах таван булаг" хувийн мал эмнэлгийн гэрээт бага эмч

56. Мэндбаярын Нармандах -Нийслэлийн "Багануур" ХК-ийн экскаваторын машинч

57. Пэрэнлэйн Нармандах -Нийслэлийн Баянзүрх дүүргийн тохижилт үйлчилгээний компанийн жолооч

58. Саруулын Онхор -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин

59. Намжигийн Отгонбилэг -Нийслэлийн шуудан холбооны 23 дугаар салбарын эрхлэгч

60. Базаррагчаагийн Отгончимэг -Нийслэлийн барилга, үйлдвэрлэл, худалдааны "М-Си-Эс Холдинг" ХХК-ийн нягтлан бодогч

61. Норовын Оюунбат -Улсын мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн төв лабораторийн химич

62. Зундуйн Оюунбилэг -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

63. Мижиддоржийн Оюунсүрэн -Дундговь аймгийн Сайнцагаан сумын мал эмнэлгийн "Тэвш-Таван-Эрдэнэ" ХХК-ийн малын эмч

64. Доржпаламын Оюунтуяа -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын тохижилт үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

65. Ванчигдоржийн Өлзийхутаг -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн ерөнхий инженерийн орлогч

66. Доржгочоогийн Равжир -Нийслэлийн "Багануур" ХК-ийн компрессорын станцын жолооч

67. Доржийн Самдан -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын Белазын жолооч

68. Цэрмаагийн Сангинням -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн материал техникийн хангамжийн баазын аккумляторчин

69. Чадраабалын Санжаажав -Сэлэнгэ аймгийн Шаамар сумын мал эмнэлэг, үржлийн "Галт сан" ББН-ийн их эмч

70. Юндэнгийн Содномцэрэн -Булган аймгийн Дашинчилэн сумын дунд сургуулийн бага ангийн багш

71. Содовын Сүхбаатар -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн холбооны цехийн ахлах мастер

72. Магван-Эрдэнийн Сэлэнгэмөрөн -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын иргэний бүртгэлийн ахлах байцаагч

73. Цагаандайн Төрбат -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн ээлжийн ахлагч

74. Дугарын Түгбадрах -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн автотээврийн байгууллагын ахлах мастер

75. Найдангийн Тэгшээ -Монголын хүүхдийн ордны сантехникийн инженер

76. Наранхүүгийн Хандсүрэн -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн чанарын хяналтын хэлтсийн хэсгийн ахлагч

77. Шаравын Хулганаа -Ховд аймгийн Жаргалант сумын 5 дугаар дунд сургуулийн үйлчлэгч

78. Даржаагийн Цогзолмаа -Улсын клиникийн төв эмнэлгийн чих, хамар хоолойн тасгийн их эмч

79. Банзрагчийн Цэрэн -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

80. Цэнджавын Цэрэнпил -Улсын клиникийн төв эмнэлгийн зүрх судас, үе судлалын тасгийн их эмч

81. Цэвээний Цэрэнхүү -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын найрал дуучин

82. Цолмонгийн Цэцэгээ -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эдийн засагч

83. Доёдын Чадраабал -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн авто тээврийн байгууллагын хэсгийн дарга

84. Чүлтэмийн Чимэг-Очир -Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын үржлийн албаны дарга

85. Бүрэнгийн Чинбат -Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын гоцлол хөгжимчин

86. Дагвараэнцэнгийн Чойжилдорж -Нийслэлийн "Монгол шуудан" ХХК-ийн шуудан хүргэгч-жолооч

87. Наянтайн Чулуунбаатар -Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын "Сударт хайрхан" хувийн мал эмнэлгийн эзэн

88. Дашнямын Шагдарсүрэн -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн барилга засварын цехийн зуурмагийн операторчин

89. Цэрэннадмидын Энхболд -Нийслэлийн Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компанийн мастер

90. Намжилпунцагийн Энхтайван -Улсын мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлэг, үржлийн хяналтын албаны дарга

91. Дамбажанцангийн Эрдэнэхүү -Нийслэлийн "Багануур" ХК-ийн үйлчилгээний хэсгийн жолооч

92. Лувсанцэрэнгийн Эрдэнэхүү -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн механикч

93. Цэрэнчимэдийн Эрдэнэцэцэг -Архангай аймгийн Өгийнуур сумын "Баянбургатай" хоршооны малын эмч

94. Ламжавын Эрдэнэчимэг -Нийслэлийн үйлдвэрлэл үйлчилгээний "Жигүүр-Гранд" ХХК-ийн угсрагч-арматурчин

95. Дэмбэрэлийн Янжмаа -Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн геологи хайгуулын ангийн дээж бутлагч

96. Цэмбэлийн Янжмаа -Говь-Алтай аймгийн Бигэр сумын "Мөнгөн буудай" хувийн мал эмнэлгийн эзэн

97. Чойжилын Янжмаа -Нийслэлийн "Гэрэлтүүлэг чимэглэл" компанийн цахилгаанчин

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэндийн Баатар-Эрдэнэ -Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 328 дугаар салбарын захирагч, хошууч

2. Пүрэвжавын Батжаргал -Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн артиллерийн зэвсэг хадгалах тасгийн дарга, хошууч

3. Самбуугийн Батмандах -Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн шатахууны дарга, хошууч

4. Чойндонгийн Бат-Өлзий -Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн штабын даргын дайчилгаа эрхэлсэн орлогч, хошууч

5. Жанцансүрэнгийн Галхүү -Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн удирдах байрны дарга, дэд хурандаа

6. Аюушийн Гончигсумлаа -Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн соёлын төвийн дарга, хошууч

7. Долгорын Жаргалсайхан -Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн артиллерийн дарга, дэд хурандаа

8. Цэдэнгийн Нармандах -Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн станцын дарга-жолооч, ахлах ахлагч

9. Санжаажавын Ойдов -Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн зэвсгийн дарга, хошууч

10. Шатарын Онхор -Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн цахилгааны инженер, хошууч

11. Дачгаагийн Самбуудорж -Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн засварын техник хадгалах тасгийн дарга, хошууч

12. Бямбын Сүхбаатар -Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

13. Лувсандашийн Цэрэнсоном -Нийслэлийн Засаг даргын дэргэдэх цэргийн болон гамшгаас хамгаалах штабын офицер, дэд хурандаа

14. Цэрэндоржийн Энхбаатар -Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн инженерийн дарга, дэд хурандаа

15. Дулмаагийн Эрдэнэбаатар -Барилгын цэргийн 110 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабанди

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

### Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын Тамгын газрын эзэмшилд байгаа 4 орон сууцыг одоо эзэмшиж байгаа оршин суугчдад нь хувьчлахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

2. "Орон сууц хувьчлах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 118 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6. Орон сууц хувьчлах тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи хугацаанд ашиглалтад орж төрийн өмчийн орон сууцны фондод шилжиж ирсэн орон сууцыг хувьчилбал Засгийн газраас эзэмшигчдэд нь хувьчлахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Төрийн өмчийн хорооноос шийдвэрлэж тэдгээрийг дуудлагын худалдаагаар худалдаж байсугай."

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Сангийн, эдийн засгийн сайд Ч.УЛААН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4, Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийн 1.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "2003 онд нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагуудын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 34 дүгээр тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтад дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а/тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн салбарын 2003 онд хувьчлах байгууллагуудын жагсаалт"-ын 4-ийн "4.Үйлдвэрлэл урлалын сургууль", "15.Монсам ХХК" гэснийг хасч, "11.Улсын цирк" гэсэн хэсгийн "Хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж хувьцааны 51 хувийг зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар" гэснийг "Менежментийн үр дүнг харгалзан" гэж өөрчлөх;

б/тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн салбарын 2003 онд өөрчлөлт, шинэчлэл хийх байгууллагын жагсаалт"-ын "5.Дархан өргөө коллеж", Барилгын шаталсан сургалттай сургалтын төв, "6.Техникийн коллеж", "7.Анагаах ухааны коллеж", "9.Хөдөө аж ахуйн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн", "10.Багшийн коллеж", "11.МУИС-ийн салбар сургууль", "12.ХААИС-ийн Алтайн бүсийн салбар сургууль" гэснийг, мөн жагсаалтын 20 дахь заалтын "Төрийн бус байгууллагын дунд төсөл сонгон шалгаруулж ..." гэснийг тус тус хасах;

в/тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "2003 онд худалдах нийгмийн салбарын төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт"-ын 2 дахь заалтын ""Их Монгол" дээд сургууль" гэсний дараа ""Мөнх-Ану" дээд сургууль, ""Монтехнологи" ХХК" гэж нэмэх.

2. Бүсийн их, дээд сургууль шинээр байгуулах асуудлыг судалж, бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг боловсруулж Засгийн газарт танилцуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Сангийн, эдийн засгийн сайд Ч.УЛААН

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.ЦАНЖИД

Эрүүл мэндийн сайд П.НЯМДАВАА

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.БАТБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

### Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Архангай аймгийн Хотонт сумын 10 жилийн дунд сургуулийг Монголын төр, нийгмийн зүтгэлтэн Солийн Данзангийн нэрэмжит болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.ЦАНЖИД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

### Ерөнхий консулыг томилох тухай

Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Ерөнхий консулаар Гомбын Сүхээг томилсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Гадаад хэргийн сайд Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

### Олон улсын байгууллагад гишүүнээр элсэх тухай

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 22.2.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Стандартчилал, хэмжил зүйн төвийг Ази, Номхон далайн лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APLAC), Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (PAC), Олон улсын лаборатори итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (ILAC)-д тус тус гишүүнээр элсэхийг дэмжиж гишүүний татварыг жил бүрийн төсөвтөө тусган санхүүжүүлж байхыг Стандартчилал, хэмжил зүйн төв (Ж.ХҮРЭЛСҮХ)-д зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Үйлдвэр, худалдааны сайд Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

### Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1991-1999 онд батлагдсан, хуучирч ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн Засгийн газрын зарим тогтоол, тогтоолын заалтыг хавсралт ёсоор хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.ЭНХТҮВШИН**

***Засгийн газрын 2003 оны 256 дугаар тогтоолын хавсралт***

### ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРИМ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

1. "Ойн нөөцийн үнэлгээ, төлбөрийн тухай" 1991 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоол.

2. "Үйлдвэрийн газар, байгууллагад онцгой дэглэм тогтоох тухай" 1991 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 21 дүгээр тогтоол.

3. "Зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдуулан удирдах ажилтан, мэргэжилтэн бэлтгэх зарим арга хэмжээний тухай" 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 23 дугаар тогтоол.

4. "Байгаль орчныг хамгаалах ажлын удирдлага, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 36 дугаар тогтоол.

5. "Говийн бүсэд мод ургуулах, ойжуулах талаар гаргасан санаачилгыг дэмжих тухай" 1991 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 49 дүгээр тогтоол.

6. "Журам батлах тухай" 1991 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 63 дугаар тогтоол.

7. "Нүүрсний хангамжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 68 дугаар тогтоол.

8. "Хэрэглээний хоршооны үйл ажиллагааг өргөтгөх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 74 дүгээр тогтоол.

9. "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцагчдын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 83 дугаар тогтоол.

10. "Цөцгийн тосны торхны хангалтын тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 86 дугаар тогтоол.

11. ""Ардын эрх" сонины талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоол.

12. "Галын аюулаас хамгаалах газрын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоол.

13. "Хууль сахиулах байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 92 дугаар тогтоол.

14. "Улсын зээллэг гаргах тухай" 1991 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 98 дугаар тогтоол.

15. "Нүүрсний уурхайнуудын хөрөнгийн чадварыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 99 дүгээр тогтоол.

16. "Хэвлэл, шуудан хүргэх ажлыг сайжруулах тухай" 1991 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 110 дугаар тогтоол.

17. "БНМАУ-ын хүндэт консулын албыг бий болгох тухай" 1991 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 133 дугаар тогтоол.

18. "Дипломат төлөөлөгчийн газрын дүрмийг батлах тухай" 1991 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоол.

19. "Улсын хил хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 141 дүгээр тогтоол.

20. "Тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 142 дугаар тогтоол.

21. "Дүрэм батлах тухай" 1991 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоол.

22. "Хүүхдийн төлөө үндэсний төв байгуулах тухай" 1991 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 151 дүгээр тогтоол.

23. "Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээ тогтоох тухай" 1991 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 166 дугаар тогтоол.

24. "БНМАУ-ын эмч хувьчлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1991 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 169 дүгээр тогтоол.

25. "Буга заазлахыг зөвшөөрөх тухай" 1991 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоол.

26. "Хөдөлмөрийн яамны дүрэмд өөрчлөлт оруулах тухай" 1991 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 174 дүгээр тогтоол.

27. "Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай" 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 182 дугаар тогтоол.

28. "Тэтгэврийн насны ахмадуудад тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 188 дугаар тогтоол.

29. "Улсын нууцын тухай" 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 206 дугаар тогтоол.

30. "Хөдөө аж ахуйн бирж байгуулах тухай" 1991 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 212 дугаар тогтоол.

31. "Байгалийн зарим баялгийг хамгаалах, ашиглалтыг журамлах, ашигласны төлбөр тогтоох тухай" 1991 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 215 дугаар тогтоол.

32. ""Засгийн газрын мэдээ" сонин бий болгох тухай" 1991 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 230 дугаар тогтоол.

33. "Ашигт малтмал ашигласны төлбөр тогтоох тухай" 1991 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 233 дугаар тогтоол.

34. "Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" 1991 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 237 дугаар тогтоол.

35. ""Засгийн газрын мэдээ" сонины талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 244 дүгээр тогтоол.

36. "Журам батлах тухай" 1991 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 247 дугаар тогтоол.

37. "Архивын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 259 дүгээр тогтоол.

38. "Журам батлах тухай" 1991 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 267 дугаар тогтоол.

39. "Журам батлах тухай" 1991 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 271 дүгээр тогтоол.

40. "Худалдааны байгууллагад хийсэн шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 277 дугаар тогтоол.

41. "Үйлдвэрлэгчийн дангаар ноёрхохыг хязгаарлах, зах зээлийн тогтолцоонд шилжих явцад гарч байгаа зарим сөрөг үзэгдэлтэй тэмцэх, зогсоох арга хэмжээний тухай" 1991 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 279 дүгээр тогтоол.

42. "Гадаадын анчдаар агнуулах ан, амьтны тоо тогтоох тухай" 1991 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 282 дугаар тогтоол.

43. "Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тавих хяналтыг өргөжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 1991 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 284 дүгээр тогтоол.

44. "Рашаан сувилал, хүүхдийн зуслангуудын харьяаллын тухай" 1991 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 315 дугаар тогтоол.

45. "Зарим яам, улсын хороо, тусгай газрын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1991 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 330 дугаар тогтоол.

46. "Буу, сум худалдах, эзэмших журам батлах тухай" 1991 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 331 дүгээр тогтоол.

47. "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1991 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоол.

48. "Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах, төлбөрт таавар, тоглоом явуулах ажлыг журамлах тухай" 1991 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 344 дүгээр тогтоол.

49. "Монголын инженерийн нийгэмлэгтэй хамтарч ажиллах тухай" 1991 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 347 дугаар тогтоол.

50. "Журам батлах тухай" 1991 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 352 дугаар тогтоол.

51. "Концерн байгуулах тухай" 1992 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоол.

52. "Монголын байгаль орчныг хамгаалах холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай" 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 46 дугаар тогтоол.

53. "Дүрэм батлах тухай" 1992 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 48 дугаар тогтоол.

54. "Тахир дутуу иргэдэд зарим хөнгөлөлт үзүүлэх тухай" 1992 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 75 дугаар тогтоол.

55. "Журам батлах тухай" 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 80 дугаар тогтоол.

56. "Валютын гүйлгээг зохицуулах зарим арга хэмжээний тухай" 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 81 дүгээр тогтоол.

57. "Патентын ажил, үйлчилгээний хураамжийн тухай" 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар тогтоол.

58. "Бугын нөөцийг хамгаалахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1992 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 87 дугаар тогтоол.

59. "Тарваганы арьс бэлтгэх, нийлүүлэх, борлуулах ажлыг шалгасан дүнгийн тухай" 1992 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 95 дугаар тогтоол.

60. "Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1992 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 105 дугаар тогтоол.

61. "Улсын ургацын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 1992 оны 8 дугаар сарын 10—ны өдрийн 1 дүгээр тогтоол.

62. "Хүний_эм, биобэлдмэл худалдаалах ажлыг журамлах тухай" 1992 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 19 дүгээр тогтоол.

63. "Журам батлах тухай" 1992 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 83 дугаар тогтоол.

64. "Монголын худалдаа, хөгжлийн банкны үйл ажиллагааны чиглэлийг тогтоох тухай" 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 8 дугаар тогтоол.

65. "Журам тогтоох тухай" 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоол.

66. ""Засгийн газрын мэдээ" сонины гаралтыг нэмэгдүүлэх тухай" 1993 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 26 дугаар тогтоол.

67. "Зарим өрхийн хүүхдийн сүүний үнийн тал хувийг улс хариуцах тухай" 1993 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 34 дүгээр тогтоол.

68. "Худалдаа, хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай" 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 56 дугаар тогтоол.

69. "Радио-телевизийн нэвтрүүлгийн чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 59 дүгээр тогтоол.

70. "Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын харьяа байгууллагын тухай" 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 74 дүгээр тогтоол.

71. "Төлбөрийн ажил зохицуулах үндэсний зөвлөл байгуулах тухай" 1993 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 109 дүгээр тогтоол.

72. "Тарвага агнасны хураамж тогтоох тухай" 1993 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 130 дугаар тогтоол.

73. "Улсын баяр наадам тэмдэглэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" 1993 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 138 дугаар тогтоол.

74. "Дүрэм батлах тухай" 1993 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 143 дугаар тогтоол.

75. "Ахмадууд болон тахир дутуу иргэдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 1993 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 145 дугаар тогтоол.

76. "НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага /ЮНИДО/-ын Монголын үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 1993 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 166 дугаар тогтоол.

77. "Орон нутагт зорчигч тээвэрлэх, шуудан,хэвлэл хүргэх ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1993 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 172 дугаар тогтоол.

78. "Патентын газрын дүрэм батлах тухай" 1993 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 180 дугаар тогтоол.

79. "Хилийн цэргийг удирдах газар байгуулах тухай" 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 186 дугаар тогтоол.

80. "Засгийн газрын хуралдааны дэгд зарим өөрчлөлт оруулах тухай" 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 193 дугаар тогтоол.

81. "Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1994 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 31 дүгээр тогтоол.

82. "Хууль тогтоомжийн акт, Засгийн газрын шийдвэрийг орон нутагт хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1994 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоол.

83. "Батлан хамгаалах яамны системд хэрэглэх суудлын автомашины тухай" 1994 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 45 дугаар тогтоол.

84. "Дүрэм батлах тухай" 1994 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 75 дугаар тогтоол.

85. "Дүрэм батлах тухай" 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 91 дүгээр тогтоол.

86. "Дундаж хэлс тодорхойлох журамд нэмэлт оруулах тухай" 1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 105 дугаар тогтоол.

87. "Зөвлөл байгуулах тухай" 1994 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 107 дугаар тогтоол.

88. "Журамд өөрчлөлт оруулах тухай" 1994 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 115 дугаар тогтоол.

89. "Дүрэм батлах тухай" 1994 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 139 дүгээр тогтоол.

90. "Журам батлах тухай" 1994 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 144 дүгээр тогтоол.

91. "Автомашин, эд хогшлыг худалдан борлуулах, шинэчлэх журмын тухай" 1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 167 дугаар тогтоол.

92. "Журам батлах тухай" 1994 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 175 дугаар тогтоол.

93. "Алтны уурхайнуудын харуул хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай" 1994 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 227 дугаар тогтоол.

94. "Журам батлах тухай" 1995 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 10 дугаар тогтоол.

95. "Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэвийн ажиллагааг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 1995 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 17 дугаар тогтоол.

96. "Журам батлах тухай" 1995 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 29 дүгээр тогтоол.

97. "Журам батлах тухай" 1995 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоол.

98. "Хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 1995 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 124 дүгээр тогтоол.

99. "Улсын нэр томъёоны комиссын бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай" 1995 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 216 дугаар тогтоол.

100. "Үндэсний зөвлөлдөх хороо байгуулах тухай" 1996 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 18 дугаар тогтоол.

101. "Журам батлах тухай" 1996 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоол.

102. "Нийгмийн халамжийн үндэсний зөвлөл байгуулах тухай" 1996 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 41 дүгээр тогтоол.

103. "Комиссын нэрийг өөрчлөх, бүрэлдэхүүнд нь нэмэлт оруулах тухай" 1996 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 74 дүгээр тогтоол.

104. "Жагсаалт батлах тухай" 1996 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 115 дугаар тогтоол.

105. "Эмийн эргэлтийн төвлөрсөн хөрөнгө бүрдүүлэх тухай" 1996 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 333 дугаар тогтоол.

106. "Ажлын байрны тодорхойлолт, ажиллах журам батлах тухай" 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 3 дугаар тогтоол.

107. "Дүрэм батлах тухай" 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 27 дугаар тогтоол.

108. "Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн талаар авах зарим арга

хэмжээний тухай" 1997 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 37 дугаар тогтоол.

109. "Хууль зүйн мэдээллийн төв байгуулах тухай" 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоол.

110. "Журамд өөрчлөлт оруулах тухай" 1997 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 129 дүгээр тогтоол.

111. "Журам батлах тухай" 1997 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 208 дугаар тогтоол.

112. "Сан байгуулах тухай" 1997 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 219 дүгээр тогтоол.

113. "Сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн алба /ҮҮГ/-ны үлгэрчилсэн дүрэм батлах тухай" 1997 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 251 дүгээр тогтоол.

114. "Лаборатори байгуулах тухай" 1998 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 61 дүгээр тогтоол.

115. "Хуульчдыг давтан сургах төв байгуулах тухай" 1998 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 68 дугаар тогтоол.

116. "Газар эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1998 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 100 дугаар тогтоол.

117. "Нэмэгдсэн өртгийн албан татварт хамруулах тухай" 1998 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 176 дугаар тогтоол.

118. "Журам батлах тухай" 1999 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 108 дугаар тогтоол.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр** **Дугаар 257** **Улаанбаатар хот**

**Улсын эталон батлах тухай**

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стандартчилал, хэмжил зүйн төв дэх цахилгаан эрчим хүчний чадлын эталоныг улсын эталоноор баталсугай.

2. Улсын эталоныг олон улсын болон гадаад орны холбогдох эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулж байхыг Стандартчилал, хэмжил зүйн төв (Ж.ХҮРЭЛСҮХ)-д даалгасугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Хүнс, хөдөө аж ахуйн сайд бөгөөд Үйлдвэр, худалдааны сайдын үүрэг гүйцэтгэгч** **Д.НАСАНЖАРГАЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр** **Дугаар 258** **Улаанбаатар хот**

**Үндэсний хороо, журмын тухай**

Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай Конвенци, Биоаюулгүй байдлын Картагенийн Протоколыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралтад гэж нэмсүгэй.

| | |
|---|---|
| "47.Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах үндэсний хороо | Байгаль орчны сайд" |

баталсугай.

2. "Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг бүртгэх, хяналт шинжилгээ хийх журам"-ыг хавсралт ёсоор

**Монгол Улсын Ерөнхий сайд** **Н.ЭНХБАЯР**

**Байгаль орчны сайд** **У.БАРСБОЛД**

*Засгийн газрын 2003 оны 258 дугаар тогтоолын хавсралт*

## ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМ, ТҮҮНИЙГ АШИГЛАН ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БҮРТГЭХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсад шинжилгээ, судалгааны үр дүнд бий болгосон болон хил дамжуулан оруулж ирсэн хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын хэмжээнд бүртгэх, хяналт шинжилгээ хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө.

2. Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулах үндэсний хороо /цаашид "хороо" гэх/ бүртгэж, хяналт шинжилгээ хийнэ.

3. Энэхүү журмын 1-д заасан амьд организм, бүтээгдэхүүнийг бүртгэх, хяналт шинжилгээ хийхдээ Монгол Улсын нэгдэн орсон Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай Конвенци, Биоаюулгүй байдлын Картагений Протокол болон холбогдох бусад гэрээ, хэлэлцээрийг мөрдөх үүрэгтэй.

### Хоёр. Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэх

4. Аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсад шинжилгээ, судалгааны үр дүнд бий болгосон болон хил дамжуулан оруулж ирсэн хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд заавал бүртгүүлнэ.

5. Монгол Улсад шинжилгээ, судалгааны үр дүнд бий болгосон болон хил дамжуулан оруулж ирсэн хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг бүртгүүлэхдээ аж ахуйн нэгж, байгууллага нь энэ тухай хүсэлт гаргана. Хүсэлтэд дор дурдсан зүйлийг тодорхой тусгасан, эсхүл хавсаргасан байна:

5.1. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн болон регистрийн дугаар, иргэний овог, нэр, регистрийн болон иргэний үнэмлэхийн дугаар, утас;

5.2. хувиргасан амьд организмын болон түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр;

5.3. генийн өөрчлөлт, хэрэглэсэн арга техник, түүний үр дүнд үүссэн хувиргасан амьд организмын шинж чанарын талаархи тодорхойлолт;

5.4. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг тодорхойлох онцлог шинж тэмдэг;

5.5. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний биоаюулгүй байдлын асуудлыг зохицуулахтай холбогдуулан эх ба хүлээн авагч /донор/ организмын ангилал зүйн статус, түгээмэл нэр, гаргаж авсан газрын нэр, тодорхойлолт;

5.6. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хүлээн авагч, эх организмын генийн олон янз байдлын эх сурвалж, гарал үүсэл, организмын амьдарч чадах буюу үржих орчин нөхцөлийн тухай мэдээлэл;

5.7. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд Биоаюулгүй байдлын Картагений Протоколын Ш хавсралтын дагуу хийгдсэн эрсдэлийн үнэлгээний тайлан;

5.8. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх зориулалтын тухай мэдээлэл;

5.9. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй аюулгүй ажиллах, тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, хэрэглэх

...ргууд, баглаж боох, бичиг баримт бүрдүүлэх, шошго хадах, устган ариутгаж аюулгүй болгох, эслын үед авах арга хэмжээтэй холбогдсон дүрэм, заавар.

6. Хороо нь улсын бүртгэлд бүртгүүлэх тухай аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн аваад эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэхэд дүгнэлт гаргуулна. Дүгнэлт гаргах шинжээчдийг хороо томилно. Дүгнэлтийг үндэслэн хороо шийдвэр гаргаж, ажлын 5 хоногт багтаан хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгэж, бүртгэлийн гэрчилгээ олгоно.

7. Хувиргасан амьд организм,түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний улсын бүртгэлийн гэрчилгээ нь дараахь бичвэртэй байна:

7.1. улсын бүртгэлийн дугаар;

7.2. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тухай мэдүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр, бүртгүүлсэн он, сар, өдөр;

7.3. хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэр;

7.4. бүртгэж, гэрчилгээ олгосон байгууллага, ажилтны албан тушаал, овог нэр, гарын үсэг.

8. Гэрчилгээ нь түүнийг олгосон байгууллагын тамга /тэмдэг/-аар баталгаажсан байна.

9. Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг Байгаль орчны сайд батална. Гэрчилгээ хэвлүүлэх зардлыг Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлнэ.

10. Хороо нь "Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэгдсэн бүртгэл"-ийг энэ журмын 5-д заасны дагуу хөтөлнө.

**Гурав. Хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд хяналт шинжилгээ хийх**

11. Аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсад шинжилгээ, судалгааны үр дүнд бий болгосон болон хил дамжуулан оруулж ирсэн хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг үндэслэн биоаюулгүй байдлын удирдамж боловсруулж, батлуулна. Удирдамжид тухайн организм, бүтээгдэхүүний эрсдэлийг арилгах үйл ажиллагааны менежментийн асуудлыг тусгана. Удирдамжийг хорооны дарга батална.

12. Монгол Улсад шинжилгээ, судалгааны үр дүнд бий болгосон болон хил дамжуулан оруулж ирсэн эрсдэлтэй байж болзошгүй хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд батлагдсан удирдамжийн дагуу эрсдэлийг арилгах үйл ажиллагааны менежментийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийнэ. Хяналт шинжилгээ хийх этгээдийг хороо тогтооно.

13. Аж ахуйн нэгж, байгууллага нь хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэхийн өмнө энэ талаар хороонд мэдээлж, хяналт шинжилгээ хийлгэх үүрэгтэй.

14. Аж ахуйн нэгж, байгууллага нь хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хувиргасан амьд организм, түүнийг ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг импортлох, экспортлох, тэдгээрийг ашиглах, эргэлтэд оруулах, худалдах, хадгалах, устгах, түүнчлэн тэдгээрээс генийн инженерчлэлийн аргаар бусад бүтээгдэхүүн боловсруулан гаргах, эсхүл гаргаж авсан зэрэг амьд организмын биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон бүх мэдээллийг хороонд өгөх үүрэгтэй.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 12 дугаар сарын 17-ны өдөр** **Дугаар 259** **Улаанбаатар хот**

**Дүрэмд нэмэлт оруулах тухай**

"Шуудангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2003 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулах, дүрэм батлах тухай" Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан "Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм"-д дор дурдсан агуулга бүхий 27 дугаар заалт нэмсүгэй:

"27. Шуудангийн алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/давуу эрхийн бүсэд шуудангийн үйлчилгээ үзүүлэгч бусад үйлчлэгчээс шуудангийн бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх хөрөнгийн талаар санал боловсруулж хорооны хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах;

2/шуудангийн нэгдсэн кодыг боловсруулж хэрэгжилтэд нь хяналт тавих;

3/тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн гомдол, маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал боловсруулж хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4/аймаг, нийслэл, хот хооронд шуудангийн илгээмж хүргэх хуваарь, чиглэлийг боловсруулах;

5/шуудангийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх арга хэмжээ авах;

6/хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг."

2. Мөн дүрмийн 3 дугаар заалтын "Харилцаа холбооны" гэсний дараа "тухай, Шуудангийн тухай", 7 дугаар заалтын "мэдээлэл, захиргааны" гэсний дараа "; Шуудангийн" гэж тус тус нэмсүгэй.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **Н.ЭНХБАЯР** |
| **Дэд бүтцийн сайд** | **Б.ЖИГЖИД** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 12 дугаар сарын 24-ний өдөр** **Дугаар 260** **Улаанбаатар хот**

**Монголд зочлох жилийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2003 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг 2004 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлсүгэй.

2. "2003 оныг Монголд зочлох жил болгох тухай" Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 257 дугаар тогтоолоор баталсан Монголд зочлох жилийн хүрээнд хийх ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнд Монголын үндэсний олимпийн хорооны ерөнхийлөгчийг нэмж оруулсугай.

3. Монголд зочлох жилийн хүрээнд 2004 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэхийг Дэд бүтцийн сайд бөгөөд Үндэсний хорооны дарга Б.Жигжидэд үүрэг болгосугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **Н.ЭНХБАЯР** |
| **Дэд бүтцийн сайд** | **Б.ЖИГЖИД** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 12 дугаар сарын 24-ний өдөр** **Дугаар 261** **Улаанбаатар хот**

**2004 оныг усны бодлогын шинэтгэлийн жил болгох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2004 оныг "Усны бодлогын шинэтгэлийн жил" болгохоор тогтоосугай.

2. Усны бодлогын шинэтгэлийн жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батлсугай.

3. Монгол орны усан хангамжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байхыг Байгаль орчны сайд, Усны үндэсний хорооны дарга У.Барсболдод үүрэг болгосугай.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | **Н.ЭНХБАЯР** |
| **Байгаль орчны сайд** | **У.БАРСБОЛД** |

Засгийн газрын 2003 оны 261 дүгээр тогтоолын хавсралт

## УСНЫ БОДЛОГЫН ШИНЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ХҮРЭЭНД 2004 ОНД ЗОХИОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|
| | а.Усны салбарын эрх зүйн орчин, нөөцийн удирдлага, зохион байгуулалт | | |
| 1 | 1.1. Усны салбарын удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх чиглэлээр асуудал боловсруулан Засгийн газарт оруулах | Ш улирал | Байгаль орчны яам |
| | 1.2. Усны салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх чиглэлээр давтан сургалт зохион байгуулах | Суулийн хагас жилд | Байгаль орчны яам, Боловсрол,соёл, шинжлэх ухааны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 1.3. Усалтын системийн эзэмшилт, ашиглалтын тухай журмыг батлан мөрдүүлэх | Ш улирал | Байгаль орчны яам, Хүнс,хөдөө аж ахуйн яам |
| 2 | 2.1. Усны үндэсний мэдээллийн сан, кадастрын нэгдсэн сүлжээ байгуулах | Ш, IY улирал | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар, Үйлдвэр,худалдааны яам, |
| | 2.2. Усны нөөцийг нэгдсэн бодлогоор ашиглах, хамгаалах, усны сав газрын менежментийн ерөнхий схемийг шинэчлэн боловсруулах | 2004 оноос эхлэн | Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 2.3. Усны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн боловсруулж батлуулах | 2004-2006 онд | Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 2.4. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа гүний худгуудыг бүртгэж, мэдээллийн санд оруулан паспортжуулах | 2004 онд | Хүнс,хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | б.Усан хангамж | | |
| 3 | 3.1. Хатуулаг, эрдэсжил ихтэй ус хэрэглэдэг дараахь сумдад ус цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах:<br>-Баянхонгор аймгийн Богд, Заг, Баян-Овоо;<br>-Увс аймгийн Наранбулаг;<br>-Ховд аймгийн Дөргөн;<br>-Дундговь аймгийн Цагаандэлгэр,Гурвансайхан;<br>-Говь-Алтай аймгийн Эрдэнэ,Есөнбулаг,Төгрөг;<br>-Завхан аймгийн Завханмандал, Ургамал;<br>-Дорноговь аймгийн Даланжаргалан;<br>-Дундговь аймгийн Луус. | 2004 онд | Байгаль орчны яам, Дэд бүтцийн яам |

| | | | |
|---|---|---|---|
| | 3.2. Ундны усны чанарын шинжилгээний лабораторийг шинэчилж, шинжилгээний үзүүлэлтийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталсан шаардлагын түвшинд хүргэх | 2004 онд | Эрүүл мэндийн яам, Дэд бүтцийн яам, Байгаль орчны яам |
| | 3.3. Усан хангамжийн төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй Өлзийт хороолол, Баянзүрх дүүргийн зарим хороодын хэрэглэгчдэд эрүүл ахуйн хэрэгцээ, шаардлагад нийцсэн ус түгээх үйлчилгээг туршин нэвтрүүлэх | Эхний хагас жилд | Дэд бүтцийн яам, Эрүүл мэндийн яам, Байгаль орчны яам, Байгаль, ой, усны нөөцийн газар |
| | 3.4. Хур тундасны усыг хуримтлуулах, урсацын тохируулга хийх, усан сан байгуулах замаар усны нөөцийг нэмэгдүүлэх, ус хэрэглээний тодорхой хэсгийг гадаргын усаар хангах ажлыг орон нутагт зохион байгуулах | 2004 онд | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар |
| | 3.5. Туул голын урсацад тохируулга хийн экологийн таатай нөхцөлийг бүрдүүлэх, Улаанбаатар хотын ус хангамжийн тодорхой хэсгийг гадаргын усаар хангах төсөл боловсруулах | 2004 онд | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газар |
| | 3.6. Хэрлэн голын урсацын зарим хэсгийг Дорноговь, Өмнөговь аймаг руу татаж эдгээр аймгийн усан хангамжийг нэмэгдүүлэх төсөл боловсруулах | Эхний хагас жилд | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 3.7. Орон нутагт хур тундасны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан байгуулах боломжтой газруудын судалгаа хийх | Ш улирал | Байгаль орчны яам, Хүнс,хөдөө аж ахуйн яам, Мэргэжлийн байгууллага |
| | 3.8."Алтанбулаг", "Замын-Үүд" худалдааны чөлөөт бүсийн ус хангамжийн эх үүсвэрийн судалгааны ажлыг хийх | 2004 онд | Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам |
| | 3.9. Улсын төсвийн хөрөнгө болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 500-гаас доошгүй худгийг засварлах, 50-иас доошгүй худгийг шинээр гаргах ажлыг зохион байгуулах | 2004 онд | Хүнс,хөдөө аж ахуйн яам, Санхүү,эдийн засгийн яам, |
| | 3.10. Орчин үеийн усалгааны болон ус өргөлт, өрөмдлөгийн техник, технологи нэвтрүүлэх зорилгоор олон улсын техникийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах | П улирал | Хүнс,хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим |

| | | | |
|---|---|---|---|
| | в. Усны нөөцийн үнэлгээ, хайгуул, судалгаа | | |
| 4 | 4.1. Ховд аймгийн нутагт мөстөл судлалын станц байгуулж, цаг уурын өөрчлөлтөөс мөстөлд үзүүлэх нөлөөг судлах | II улиралд | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 4.2. Баруун бүсийн төв Ховд, Улиастайн усны нөөцийг тодорхойлох | II улиралд | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 4.3. Аж ахуйн нөлөөнд ихээр өртсөн Орхон голын сав газарт экосистемийн төлөв байдлын нэгдсэн үнэлгээ хийх | 2004 онд | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 4.4. Урьд баригдсан усан сангуудыг усан хангамж, ус хуримтлуулах зорилгоор ашиглах талаар төсөл боловсруулах | 2004 онд | Байгаль,ой,усны нөөцийн газар |
| | 4.5. Газрын доорхи усны ажиглалтын өртөөг нэмэгдүүлэх | III улирал | Байгаль орчны яам, Байгаль,ой,усны нөөцийн газар |
| 5 | 5.1. Алтны шороон ордуудын ашиглалтын явцад голын голдиралыг хамгаалах, нөхөн сэргээх журам боловсруулан мөрдүүлэх | 2004 онд | Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын алба, Байгаль,ой,усны нөөцийн газар, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар |
| | 5.2. Үйлдвэр, уурхайн зориулалтаар ашигласан усыг эргүүлэн ашиглах технологийн горим боловсруулан мөрдүүлэх | 2004 онд | Байгаль орчны яам, Дэд бүтцийн яам, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын алба |
| | 5.3. Бохир усыг шаардлагын түвшинд хүртэл цэвэршүүлэн байгалийн усанд нийлүүлж байх стандарт, журмыг шинэчлэх | 2004 онд | Байгаль орчны яам, Дэд бүтцийн яам, Үйлдвэр, худалдааны яам |
| | 5.4. Уидны усны эх үүсвэрийг хамгаалах, ариун цэврийн болон хамгаалалтын бүсийн дэглэм мөрдүүлэх | III улирал | Байгаль орчны яам, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын алба, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Байгаль,ой,усны нөөцийн газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5